

ТӨВ АЙМГИЙН 2022 ОНЫ 08 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2022 оны 09 сарын 05-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2022 оны 08 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 4 дүгээр хуралдаан хуралдлаа. Тус Хуралдаанаар 10 асуудал хэлэлцсэнээс:

- Аймгийн зарим сумдын байгалийн өвөрмөц тогтоцтой газар, ховор ан амьтан, ургамлын нөөцтэй газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай асуудлыг боловсруулалтын түвшинг сайжруулахаар төсөл өргөн баригчид буцаав.

- Төв аймгийн Сүмбэр сум, Сэлэнгэ аймгийн Баянгол сумтай хиллэдэг хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал уламжлах тухай асуудалыг хэлэлцэж Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд

- Сэргэлэн, Мөнгөнморьт сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай,

- Сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай,

- Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл уламжлах тухай асуудлуудыг Хурлын хот суурин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийн хороонд

- Мөн Аймгийн ИТХ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тухай асуудлыг Хурлын Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хороонд

- Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг Хурлын бүх хороодод тус тус шилжүүлсэн байна.

Гадаад харилцааны хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Даргын 2022 оны 193 дугаар албан бичгээр БНСУ-ын Бие даасан Чезу хотын ИТХ-ын Төлөөллийг Төв аймагт албан айлчлал хийх урилга хүргүүлэн Уузалтыг 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс 09 дүгээр сарын 03-ны өдрүүдэд хийхээр товлон бэлтгэл ажлыг хангах хүрээнд аймгийн ИТХ-ын Даргын 22 дугаар Захирамжаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Энэ сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 1 өргөдөл бүртгэгдсэн. Үүнд: Зуунмод сумын 1 иргэнээс Төв аймгийн Сэргэлэн сумын 4-р баг “HERO” сувиллын эсрэг талд автозамын дагуу уулын хажуугаас хайрга чулуу олборлож байгаа мэдээллийг өгч, шалгуулахыг өргөдлийг аймгийн Засаг дарга руу шилжүүлсэн.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 07 сарын 04, 18, 08 сарын 01, 30-ны өдрүүдэд танхимаар 4 удаа зохион байгуулж, тэмдэглэлээр 68 заалт бүхий үүргийг холбогдох байгууллага, суманд хүргүүлж, хэрэгжилт тооцов.

“Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д туссаны дагуу 07 сарын 06, 08 сарын 03-ны өдрүүдэд “Иргэдтэй уулзах цаг” зохион байгуулж, аймгийн Засаг даргын орлогч Г.Сурмаа, Зуунмод сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч Ч.Сарангэрэл иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, хариулт өгөв. Уг арга хэмжээний үеэр иргэдээс гарсан 23 санал, хүсэлтийг хяналтын картаар холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлэлээ. Дараа сарын “Иргэдтэй уулзах цаг” арга хэмжээг 09 сарын 07-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааныг 2 удаа хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажилласан. Уг 2 удаагийн хуралдаанаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 81 иргэний тодорхойлолтыг хэлэлцүүлж, холбогдох

байгууллагаас дүгнэлт авч ажиллалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилж ажиллав.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаан 2 удаа хуралдаж 16 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн. Аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн барих 6 асуудлыг холбогдох бодлогын хэлтсүүдээс авч өргөн барьсан.

ЗГ-ын Иргэд олон нийттэй харилцах 1111 төвд 08 сарын 31-ний байдлаар 157 санал, хүсэлт, гомдол талархал ирсний 151-ийг шийдвэрлэн иргэнд хариу өгсөн бол 6 нь судлагдах шатандаа байна.

ТАЗ-өөс Хүний нөөцийн аудитын шалгалт манай аймагт 2022 оны 09 дүгээр сард ирэх төлөвлөгөө гарсантай холбогдуулан бэлтгэл ажлыг ханган албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн, жигдрүүлж ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн нэрийн хуудасны стандарт гарсантай холбогдуулан сумд, харьяа байгууллагын албан хаагчдад ДУС-р шинэ стандартыг дагаж мөрдөх тухай мэдээ хүргэсэн.

МУИС, МҮТИС-н бакалавр болон магистр, докторын хөтөлбөрийн мэдээллийг сумд, харьяа байгууллагын албан хаагчдад мэдээ хүргүүлж мэргэжил мэдлэгээ дээшүүлэх боломжыг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар “Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц”-ыг хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн мэдүүлэв. Хэрэгжилтийн явцын товчоог харуулбал:

№	Бүлэг	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Дундаж үнэлгээ
				100%	70-99%	31-69%	0-30%	
1	2	3	4	5	6	7	8	9
1	“Ковид – 19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	3	9	6	0	3	0	85,9
2	Хүний хөгжлийн бодлого	19	69	19	26	19	5	75,85
3	Эдийн засгийн бодлого	2	10	2	5	3	0	79
4	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлого	3	38	13	16	7	2	78,54
5	Ногоон хөгжлийн бодлого	5	26	3	8	11	4	62,03
6	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	8	48	14	12	8	14	65,54
7	Засаглалын бодлого	11	55	14	22	14	5	71,35
8	Аймаг, сум, нийгэм, эдийн засгийн салбар үүсч байгуулагдсаны түүхт ой угтсан бүтээлч ажил	1	2	0	0	2	0	40,14
Нийт/Дундаж		52	257	71	89	67	30	72,16%

Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулах иргэдийн материалыг хүлээн авч нэгтгэн зөвлөлийн гишүүдэд танилцуулж Захирамж гаргуулан шагналыг гардуулсан.

Гимамура Хакуба эрх баригч намын дэд дарга, Япон улсын парламентийн дарга М.Хаяаши, Вада сангийн тэргүүн нар Төв аймагт хүрэлцэн ирж Засаг дарга Д.Мөнхбаатар, Засаг даргын орлогч Г.Сурмаа нартай уулзалт хийв.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

2022 оны 08 дугаар сард аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **15** байгууллага **500 гаруй** төрлийн үйлчилгээг **4610** иргэнд, өдөрт дунджаар **200-250** иргэнд хүргэн үйлчилсэн байна.

Тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем /E-mongolia/- ийг нэвтрүүлсэн бөгөөд тус системээр дамжуулан 08 сард аймгийн хэмжээнд **640** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас **411** лавлагаа үйлчилгээ авсан.

Харин Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **11** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан, одоогийн байдлаар шийдвэрлэх хугацаа болоогүй 11 гомдол байна.

Байгууллагын цахим мэдээллийн буланд байх ухаалаг дэлгэцүүдээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан нийт **187** иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан **51** иргэн машины татвар, торгууль төлөх, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авсан.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Алба хаагчдыг гал түймэр, гамшиг ослын голомтод болон дасгал сургуулийн үед үүрэг гүйцэтгэхдээ аюулгүй байдлыг ханган, тактикийн алдаа дутагдал гаргуулахгүй байх зорилгоор “Гал түймэр унтраах дүрэм”, “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”, “Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм”-ээр давтан сургалт явуулж шүүлэг авсан.

Баян сумын нутагт орших “Майн Тех Бластинг” ххк-ийн тэсрэх материалын агуулах, заамар сумын нутагт орших “Топ Ган Дриллинг” ххк-ийн алтны ил уурхай, заамар сумын нутагт орших “Юбиксолюшн” ХХК-ийн алтны шороон ордны ил уурхайн гамшигийн эрсдэлийн үнэлгээний тайланд анхан шатны дүн шинжилгээ хийж Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлээ.

Монгол улсын шадар сайдын баталсан нэгдсэн хуваарь, удирдамжийн хүрээнд “Худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч нар гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллалаа.

Шалгалтад Төв аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээний байгууллагуудад нийт 8 байгууллага хамрагдсанаас гал түймэр гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй 52 зөрчил илэрснийг цаг хугацаа шаардагдах 4 зөрчилд үүрэг өгч ажиллалаа.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ний өдөр баталсан нэгдсэн хуваарь, удирдамжийн хүрээнд Их, дээд сургууль, коллеж ЕБС-ын оюутан сурагчдын дотуур байруудын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч нар гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллалаа.

Шалгалтад Төв аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээний байгууллагуудад нийт 3 байгууллага хамрагдсанаас гал түймэр гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй 21-н зөрчил илэрснийг цаг хугацаа шаардагдах 1 зөрчилд үүрэг өгч ажиллалаа.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 21 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 143 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 86 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өгч ажилласан байна.

Аймгийн хэмжээнд баригдах 12 барилгын зураг төслийг хянаж, дүгнэлт бичиж холбогдох дансанд зураг хяналтын 600,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна. Хяналт шалгалтад хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 29 аж ахуйн нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрөл олгож ажиллаа.

Монгол Улсын Шадар Сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан “Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”, 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн “Үер, уснаас үрсээ хамгаалъя” аяны удирдамж, аймгийн Засаг даргын 2022 оны

“Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх тухай” А/395 дугаар захирамжийн хүрээнд Онцгой байдлын газрын даргаар Онцгой байдлын газрын салбар, нэгжүүдийг хамруулсан нэгдсэн удирдамж гарган хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Аймгийн Засаг даргаар 2022.06.29-ний өдөр “Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх тухай” А/395 дугаар захирамж, үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг батлуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 6,456,400 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн ажилласан.

Тус аяны хүрээнд аймгийн Засаг даргын захирамж 1, төлөвлөгөө 1, удирдамж 3, аймгийн Онцгой комиссын албан даалгавар 1 боловсруулж, 27 сумын Засаг даргын тамгын газарт хүргүүлэн хэрэгжилтийг хангасан.

“Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бэлэн байдлаа хангах” сэдвээр танхимын сургалтыг аймгийн хэмжээнд 11 байгууллагын 453 алба хаагчдыг хамруулан зохион байгуулж 3 төрлийн 1359 ширхэг гарын авлага, тараах материалыг тараан ажилласан.

Аяны хүрээнд Онцгой байдлын газрын нийт бие бүрэлдэхүүнд “Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бэлэн байдлаа хангах”, “Үер уснаас үрсээ хамгаалья” аяны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгч, бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллалаа.

Онцгой байдлын газраас үер, уснаас урьдчилан сэргийлэх гарын авлага - 3 төрөл, үер, уснаас үрсээ хамгаалья гарын авлага, постер - 3 төрөл нийт 6 төрлөөр гарын авлага боловсруулан иргэд, олон нийт, цахим сүлжээнд сурталчилан ажилласан.

“Үер, уснаас үрсээ хамгаалья аян”-ы хүрээнд Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газартай хамтран “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж нийт 342 иргэнд 568 ширхэг гарын авлага тараан мэдээ мэдээллээр ханган ажилласан.

Онцгой байдлын газраас Зуунмод суманд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон худалдаа, үйлчилгээний газар, төрийн бус байгууллага, зэрэг нийт 96 хуулийн этгээд, Лүн, Баян, Батсүмбэр, Мөнгөнморьт сумдын хүн ам олноор цуглардаг үйлчилгээний газруудын нийт 56 мэдээллийн самбарт 3 төрлийн стикер наалтыг нийт 456 ширхгийг хэвлүүлэн байршууллаа.

Аймгийн хэмжээнд усны ослын дуудлага бүртгэгддэг эрсдэл бүхий Заамар, Лүн, Мөнгөнморьт, Батсүмбэр, Алтанбулаг, Өндөрширээт сумдад үер, усны ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг самбарыг 36 ширхэгийг байршуулан ажилласан байна.

Орон нутгийн ТБС телевиз, аймгийн Улаанзагалмайн хороотой хамтран “Үер, уснаас үрсээ хамгаалья” аяны хүрээнд сэрэмжлүүлэх шторкийг бэлтгэж байгууллагын пэйж хуудас болон ТБС телевизээр ард иргэдэд өдрийн 3 удаагийн давтамжтайгаар нийт 1024 удаа хүргэсэн.

Байгууллагын фейсбүүк хуудсанд 42 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, вейб сайтад 12 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө, зөвлөмжийг 12 удаа, нийт 24 удаагийн мэдээ, мэдээллийг байршуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажилласан бол аймгийн хэмжээнд 27 сумын 56 сайтад мэдээ мэдээлэл, зөвлөмжийг тухай бүр байршуулан нийт 1265 мэдээ мэдээлэл байршуулсан байна.

Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэг, сурталчилгаг шат дараатай зохион байгуулах, бага насны хүүхдийн усны ослын тоо давтамжийг багасгах, эцэг эх, асран хамгаалагчид усны ослын талаарх мэдээ мэдээлэл, зөвлөмжийг хүргүүлэх чиглэлээр Батсүмбэр, Алтанбулаг, Заамар, Өндөрширээт, Лүн, Мөнгөнморьт сумдад Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт, сумдын Онцгой комисс, мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажилласан.

Төв аймгийн Онцгой байдлын газрын харъяа Лүн сум дахь Эрэн хайх аврах бүлэг, Мөнгөнморьт сум дахь Гал түймэр унтраах аврах 75-р ангийн алба хаагчидтай хамтран газрын даргын баталсан удирдамжийн дагуу 15 алба хаагч 6 авто машин, 2 завьтай Туул, Хэрлэн, Тэрэлж голын эрэг орчмоор амралт зугаалгаар аялаж, дамжин өнгөрч буй 8965 авто машин 19568 иргэнд 6 төрлийн 26895 ширхэг сэрэмжлүүлэх гарын авлага, тараах материалыг тараан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд өнгөрсөн оны 06, 07, 08 дугаар сард 8 иргэн усны ослоор амь насаа алдсаны 3 нь бага насны хүүхэд байсан бол 5 насанд хүрсэн хүн байсан.

2022 оны 06,07,08 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 4 иргэн гол нуурын усанд осолдож амь насаа алдсаны 2 нь бага насны хүүхэд байна. Усны ослын дуудлагыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Малын гоц халдварт өвчин: Мал амьтаны гоц халдварт өвчин 3 батлагдаж Алтанбулаг /2022.08.19 ны өдрийн А/82 тоот захирамж/, Баянцагаан /2022.08.12 ны өдрийн А/112 тоот захирамж/, Баян-өнжүүл /2022.08.19 ний өдрийн А/115 тоот захирамж/ хорио цээрийн дэглэмтэй байна.

Усны осол: Эрдэнэ сумын Чулуут 2 дугаар багийн нутаг "Хагийн хар нуур" гэдэг газарт Төв аймгийн Эрдэнэ сумын Өгөөмөр баг Баруун сухайд оршин суугч иргэн Б.Батдорж /26 настай эрэгтэй / 2022.08.08-ны өдөр "Хагийн хар нуур" руу морио шумбуулах гэж ороод усанд живсэн. Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбараас 6 алба хаагч, 1 автомашинтай, 1 сэлүүрт завьтай, ар гэрээс 3 хүн, 17 морь 1 автомашинтай, Төв аймгийн Цагдаагийн газраас 3 алба хаагч, 1 автомашинтай, нийт 12 хүн 3 автомашинтай 17 морьтой, 2022.08.11-ний өдрийн 07:30 цагт эрлийн ажиллагааг эхлүүлж, 8-10 метрийн гүнд 2 удаагийн шумбалт хийж 11:42 цагт усанд нэрвэгдэгчийн цогцсыг уснаас гаргаж, Төв аймгийн Цагдаагийн мөрдөн байцаагч, дэслэгч С.Жигжидсүрэн шилжүүлэн өгсөн.

Үер: Эрдэнэсант сумын Угалзат 4 дүгээр багийн нутаг Оргиот гэх газар 2022.08.18-ны өдрийн 23:35 цагаас 2022.08.19-ний өдрийн 01:15 цаг хүртэл үргэлжилсэн хүчтэй аадар бороо, 2.5см голчтой мөндөр орсны улмаас Эрдэнэсант сумын харьяат малчин Г.Баатарзоригт, Л.Мөнхбаяр, Д.Баасансүрэн, Д.Дагвасүрэн, Б.Аюуш нарын 1000 гаран бог мал "Оргиот" нуурын усруу урсаж орсон. Орон нутгаас 26 хүн, 8 автомашинтай ажилласан.

Гал түймэр: Объектын гал түймрийн 2, ой, хээрийн түймрийн дуудлага мэдээлэлгүй.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Батсүмбэр сумын иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийн дагуу Батсүмбэр сумын Баянголын ам Түшээ гүн орчмын газар олголт, ашиглалтын байдалд шалгалт хийгдэж байна. Тухайн газарт хяналтын хэмжилт хийлгэх шаардлагатай тул газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 316 дугаар хамтран ажиллах тухай албан бичгийг аймгийн ГХБХБГазарт хүргүүлсэн.

Газрын даргын баталсан 19/33 дугаар удирдамжийн хүрээнд Баяндэлгэр сумын Галуут 2 дугаар багийн нутаг Шар булаг гэх газар MV-021581 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч "Говийн ертөнц" ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн хамтарсан 12 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн.

Газрын даргын баталсан 19/48 дугаар удирдамжийн хүрээнд Батсүмбэр сумын Засаг дарг, Газрын даамал нарын 2021, 2022 оны газар олголтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, хуульд нийцээгүй шийдвэр гаргасан, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5, 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.4 дэх заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг зөрчиж олгосон нийт 22 нэгж талбарыг хүчингүй болгох улсын байцаагчийн 19-04-031/54 дугаар хугацаатай 5 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн. Зуунмод, Эрдэнэ, Баянчандмань сумын Засаг дарга, газрын даамал нарын газар олголтын байдалд хяналт шалгалт хийгдэж байна.

Төв аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/428 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн удирдамжийн хүрээнд Баян, Баянжаргалан, Баянцагаан, Сэргэлэн, Заамар сумдын нутагт ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч 35 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд Хар занар, Эрдэнэ майнинг үйлс, Цэцэнс майнинг энд энерги, Баянхуурай, Минжит булган гол, Чилагу, Э-транс ххк-ууд үйл ажиллагаа явуулаагүй байна.

Хүдэр эрдэнэ ххк-д 19-04-031/65, Шижиргоулд ххк-д 19-04-031/64, Эрдэнэ дорно ххк-д 19-04-031/63, Шохой цагаан булаг ххк-д 19-04-031/57 дугаар 18 заалт бүхий албан шаардлага, Принципал инвенстментс, Үүртгоулд, Монголчех металл, Тэвхэн ххк-уудад улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага тус тус хүргүүлж, Ноён гари, Галзоо хан ххк-уудын үйл ажиллагааг улсын байцаагчийн хамтарсан актаар зогсоосон.

Газрын даргын баталсан 19/47 дугаартай удирдамжаар Төв аймгийн Батсүмбэр суманд үйл ажиллагаа явуулж буй амралт, сувилал, хүүхдийн зуслан 16 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Батсүмбэр сумын Цогт-Өндөр 2 дугаар багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй Жо-Интернэшнл ХХК-ийн Баян байгаль амралтын газар, Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Баянбуурал амралтын газар, Баян буурал хараа гол ХХК-ийн Баянхангай амралтын газар, Сөгнөгөр баянгол 3 дугаар багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй Баянгол ресорт девелопмент ХХК-ийн Баянгол эко амралтын газар, Мөрөөдөл хүүхдийн зуслан, Хорим согчу холдинг ХХК-ийн Аваргууд амралтын газруудад тус тус зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж Баян байгаль амралтын газарт зөрчлийн тухай хуульд заасны дагуу арга хэмжээ авч, Мөрөөдөл хүүхдийн зуслан, Баянгол эко, Баянбуурал, Баянхангай, Аваргууд амралтын газруудыг Төв аймгийн Прокурорын газрын 2022 оны 08 дугаар сарын 08-ний өдрийн 01, 02, 03, 04, 05, дугаартай тогтоолоор үйл ажиллагааг нь түр зогсоож зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийгдэж байна. Мойлтой тохой ХХК-ийн Моностой амралтын газарт ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулаагүй зөрчилд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Шалгалтын ажил үргэлжилж байна.

Төв аймгийн Прокурор, Цагдаагийн газраас харьяаллын дагуу шилжин ирсэн тарвага агнасан гэх 3, ганга түүж бэлтгэсэн гэх 1 зөрчилд зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж Төв аймгийн Прокурорын газрын хяналтын Прокурорт хүргүүлсэн.

Төв аймгийн Засаг даргын 2022 оны 7 дугаар сарын 28 өдрийн А/428 тоот захирамжаар батлагдсан ажлын хэсэг Төв аймгийн Баян, Баянцагаан, Баянжаргалан, Эрдэнэ, Сэргэлэн, Заамар сумдын нутагт уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч 65 аж ахуйн нэгж, 13 бичил уурхайн нөхөрлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд 25 аж ахуйн нэгж, 6 бичил уурхайн нөхөрлөлийн үйл ажиллагаа явуулаагүй байна.

Шалгалтаар ил уурхайн аюулгүй байдлын дүрмийг мөрдөж ажиллаагүй уурхайн талбайд тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэг хангалтгүй, маркшейдрийн хэмжилт тогтмол хийдэггүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн 25 улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлж, уурхай дээр байх ёстой баримт бичгийн бүрдэлгүй, батлагдсан зураг төслийн дагуу үйл ажиллагаа явуулаагүй 4 аж ахуйн нэгжийг улсын байцаагчийн актаар түр зогсоож, 7 аж ахуйн нэгжид Зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

Тусгай зөвшөөрөлгүй талбайд үйл ажиллагаа явуулсан, ашигт малтмалын ашиглалт олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлтийг зохих журмын дагуу хийгээгүй, Туул голын онцгой хамгаалалтын бүсэд хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулсан 5 аж ахуйн нэгжийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 314, 315, 324 тоот албан бичгээр тус тус Төв аймаг дахь Цагдаагийн газарт харьяаллын дагуу шилжүүлсэн.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 19/03 дугаартай “үйлдвэрийн осол, хурц хордлогын актыг хянан баталгаажуулах тухай” удирдамжийн дагуу Тэнхун ХХК-д гарсан 2 үйлвэрийн ослын актыг хянан баталгаажуулж, Хаппи бьюлдинг ХХК-д гарсан 1, Илт гоулд гарсан 1 үйлдвэрийн ослыг хянаж байна.

Газрын даргын баталсан 19/34 дугаартай “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын хэлтэст тэтгэврийн даатгалын сангийн 2020, 2021 оны төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтыг анхан шатны болон санхүүгийн үндсэн баримтад хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар тэтгэвэр нөхөн олгуулахаар 9,9 сая төгрөгийн акт, тэтгэвэр нөхөн төлүүлэх 3,7 сая төгрөгийн акт, зөрчил арилгуулахаар 3 заалттай албан шаардлага хүргүүлсэн.

Баталгаажуулалтын хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн барилгад шалгалт хийж, барилгын ашиглалтын төлөв байдлын тухай 1 дүгнэлт, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагчийн 1 заалт бүхий 1 албан шаардлага боловсруулж хүргүүлж ажиллалаа.

Төв аймгийн Зуунмод сумын Номт 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын захиалгаар “Орхонконструкшн” ХХК-ийн боловсруулсан зураг төслөөр “Ирксибстрой” ХХК-ийн гүйцэтгэж буй 90 айлын орон сууцны барилгын угсралтын гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн 19-06-019/28, 19-07-020/17 дугаартай албан шаардлагуудад тусгагдсан зөрчлийн заалт бүрийг бүрэн арилгаагүй зөрчил илэрч, улсын байцаагчийн үйл ажиллагаа зөрчил арилгах хугацаагаар түр зогсоох тухай хамтарсан акт боловсруулан, хүргүүлж ажилласан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оноос Мөнгөнморь суманд баригдаж буй сургуулийн дотуур байрны барилгын угсралтын ажил, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Сэргэлн суманд баригдаж буй ахуйн үйлчилгээний төвийн барилгад тус тус хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Нийтийг хамарсан баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээний үеэр урьдчилан сэргийлэх хяналт хийх тухай 19/40 дугаартай удирдамжийн хүрээнд Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор хурдан морьны уралдааны үеэр морьны үүлдэр, стандартын хяналт тавьж ажилласан.

Нийтийг хамарсан баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээний үеэр урьдчилан сэргийлэх хяналт хийх тухай 19/40 дугаартай удирдамжийн хүрээнд Баяндэлгэр, Эрдэнэ, Зуунмод, Мөнгөнморьт сумдын 138 хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулж улсын байцаагчийн 28 заалттай 2 албан шаардлага, 864 заалттай 48 зөвлөмж, үйл ажиллагааг түр зогсоох тухай 1 акт үйлдэж хүргүүлсэн. Хяналт шалгалтын явцад 247 зөрчил, дутагдал илрүүлж, 221 буюу 90.7%-ийг газар дээр нь арилгуулж хадгалалтын хугацаа дууссан, гарал үүсэл тодорхойгүй 24 нэр төрлийн 3.2кг, 184 ширхэг 1.345 мянган төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг хураан авч Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.

Барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийх тухай 19/12 дугаартай удирдамжийн хүрээнд 34 барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийж зөвшөөрсөн 12, буцаасан 2 дүгнэлт үйлдэж хүргүүлсэн.

Нийтийг хамарсан баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээний үеэр хоол хүнснээс гаралтай халдвар, хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор 29 иргэн аж ахуйн нэгжийн 4 нэр төрлийн бүтээгдэхүүнээс 31 ширхэг дээж авч нян судлалын шинжилгээнд хамруулсан.

Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл сунгах үед хяналт хийх тухай 19/10 дугаартай удирдамжийн хүрээнд үйл ажиллагааны тухай 3 дүгнэлт, Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 19/40 дугаартай удирдамжийн хүрээнд 1 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж шинжилгээний дүнгийн тухай 1 дүгнэлт, үйл ажиллагааны тухай 1 дүгнэлт, төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай 19/01 дугаартай удирдамжийн хүрээнд 1 иргэний үйл ажиллагаанд шалгалт хийж үйл ажиллагааг түр зогсоох тухай 1, сэргээх тухай 1 акт, 18 заалттай улсын байцаагчийн 1 албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан.

Суурьшлын бүсийн хөрсөнд хяналт шинжилгээ хийх тухай 19/36 дугаартай удирдамжийн хүрээнд 3 хөрсний дээж авч шинжилгээнд хамруулсан. Ундны усны чанар, аюулгүй байдалд хяналт шинжилгээ хийх тухай 19/13 дугаартай удирдамжийн хүрээнд 5 дээж авч шинжилгээнд хамруулсан.

Эрүүл ахуй нян судлалын лаборатори нь хяналт шалгалт болон аж ахуй нэгж иргэдийн хүсэлтээр нийт 19 дээжинд 51 үзүүлэлт / гүний усны 9 сорьцонд 18, төвлөрсөн системийн ус 2 сорьцонд 6, Хөрс 3 сорьцонд 9, Ариутгал халдваргүйтгэлийн бодис 1 сорьцонд 1,Төмс хүнсний ногоо 1 сорьцонд 2, Консервлосон махан бүтээгдэхүүн 2 сорьцонд 14, Агаар 1 сорьцонд 1,/ үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан. Үүнээс: Стандартын шаардлага хангаагүй 1 сорьцонд 1 үзүүлэлт байна.

Эрүүл ахуй химийн лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 24 сорьцонд 61 үзүүлэлтээр /Төмс хүнсний ногооны 13 дээжинд 26 үзүүлэлтээр,Гүнийн ус 2 дээжинд 26 үзүүлэлтээр, Хоолны 8 дээжинд 8 үзүүлэлт,ариутгалын бодис 1 дээжинд 1 үзүүлэлт / эрүүл ахуй химийн шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан байна. Үүнээс: эерэг стандартын шаардлага хангаагүй дээж илрээгүй болно.

Нэгж лабораториудад: нийт 43 сорьцонд 112 үзүүлэлтээр шинжилгээг хийж үр дүнг цаг хугацаанд нь хянаж, баталгаажуулан гаргасан.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Нутгийн удирдлагын байгууллага орон нутгийн хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа, ажлын уялдааг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс аймгийн Прокурорын газрын үйл ажиллагаатай танилцаж ажил хэргийн уулзалт зохион байгууллаа.

Хууль зүйн салбарын 2022 оны хагас жилийн тайланг зурагт хуудас, инфографик хэлбэрээр бэлтгэн олон нийтэд сурталчиллаа.

Хууль зүйн салбарын хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс болон орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд санал хүргүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 30 айлын орон сууцыг барих асуудлаар Хууль зүй, дотоод хэргийн яам, холбогдох байгууллагад санал уламжиллаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Баян, Баянжаргалан, Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Хууль, эрх зүйн мэргэжилтэн нарт нотариатын үүргийг хавсран гүйцэтгэх эрх олголоо. Шинээр томилогдсон сумдын нотариатын үүргийг хавсран гүйцэтгэгч нарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Төрийн архивын эх баримтаас байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 109 иргэний хүсэлтийг хүлээн авч 795 хуулбар хувь, 76 лавлагаа, 134 сан хөмрөгийн 527 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүлж орон нутгийн төсөвт 1,0 төгрөгийг орууллаа.

4 хөмрөгийн 95 хадгаламжийн нэгжийн 5700 хуудас захирамжлалын баримт бичгийг скайнарадаж, цахим хэлбэрт шилжүүллээ. 1 хөмрөгийн 74 хадгаламжийн нэгжийн 4268 хуудас баримтанд ялгалт хийж хуудас дугаарлах ажлыг зохион байгууллаа.

Баримтын нөхөн бүрдүүлэлтээр “Бадамлах ХХК”, Эрдэнэ сумын аж ахуйн зориулалтай гадна цахилгаан хангамжийн 2 хадгаламж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн 20 хадгаламж нийт 22 хадгаламжийн нэгжийг хүлээн авч хадгаламжийн санд бүртгэлээ.

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 63.697 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138.282 газар өмчлөх эрхийн 52.146 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 1088 /8 сард хүлээн авсан мэдүүлэг /1088/

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу улсын төсөвт 417,7 сая төгрөгийг орууллаа.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2810 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 15 нэмэлт өөрчлөлт, шинээр 30 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 0, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 7, эцсийн өмчлөгч 38 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 4 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 16 лавлагаа өгсөн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого 15,1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 512 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 73,8 хувиар өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 51.3 хувь байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-10, шүүхээр баривчлагдсан-56, албадан саатуулсан-8, ар гэрт нь 6 иргэнийг хүлээлгэн өгч, нийт 80 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу биед эрүүл мэндийн үзлэг хийж, хүлээн авч ажиллалаа.

Төв аймгийн Баянцагаан суманд “Төв түмний цэнгэл-2022” баяр наадам зохион байгуулсантай холбогдуулан хамгаалалтад 30 алба хаагч, Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт зохион байгуулсан Төвийн бүсийн залуучуудын чуулга уулзалтад 8 алба хаагч ажиллаж олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллалаа.

Алтанбулаг сумын Аргал 2-р баг, Баянцагаан сумын Өлзийт 1-р баг, Баян-Өнжүүл сумын Бүрд 3-р багийн нутагт дэвсгэрт бог малын гоц халдварт өвчин гарч хяналтын 4 цэг ажиллуулж хяналт тавин ажиллаж байна.

2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдөр хүртэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 113 жолоочийг илрүүлж, 74 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 39 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэж ажиллалаа.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 6511 жолоочийг 199,8 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 98 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулж зөрчлийг арилгууллаа.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Криминалистикийн шинжилгээ-126, магадлан шинжилгээ-127, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-47, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-132, гарын хээний санг дардсаар баяжуулсан-66, мөрөөр баяжуулсан-69, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-126, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-182, гистологийн шинжилгээ-182 тус тус хийгдлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
8-р сар	217	490	9	698	352	346	50,4
	4587209.8	2200536,2	178844.7	6608901,3	2113020,2	4495881,1	

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2022 оны А/300 тоот захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу “Ерөнхий сайдын шуурхай хэрэгжилтийн” 104 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 90.1 хувийн хэрэгжилттэй ЗГХЭГазарт хүргүүллээ. Үүнээс:

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо				104
1	Бүрэн хэрэгжсэн	□□□□□ □□□□□□□□□□	100%	77
2	Хэрэгжих шатанд	□□□□□□□□□ □□□□□ □□□□□	70%	17
3	Хэрэгжилт хангалтгүй	□□□□□□□□□□ □□□□□□□□ □□□□	30%	7
4	Хэрэгжээгүй	□□□□□□□□□ □□□□	0%	-
5	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	□□□□□□□□□□ □□□□□□□□□□□□	Х.Б	3
Хэрэгжилтийн дундаж				90.1%

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2022 оны А/300 тоот захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 36 тогтоолын 99 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, мэдээг аймгийн Засаг даргын зөвлөл, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, 85.25 хувийн хэрэгжилттэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд өргөн мэдүүллээ.

Д/д	Хэрэгжилт гаргасан заалтын тоо	36/99		
1	Бүрэн хэрэгжсэн	□□□□□ □□□□□□□□□□	100%	52
2	Хэрэгжих шатанд	□□□□□□□□□ □□□□□ □□□□□	70%	43
3	Хэрэгжилт хангалтгүй	□□□□□□□□□□ □□□□□□□□ □□□□	30%	2
4	Хэрэгжээгүй	□□□□□□□□□ □□□□	0%	-
5	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	□□□□□□□□□□ □□□□□□□□□□□□	Х.Б	2

Хэрэгжилтийн дундаж	□□□□□□□□□□ □□□ □□□□□□□□	85.25%
----------------------------	-------------------------	---------------

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VIII хуралдааны Төлөөлөгчдөөс гарсан 24 саналын явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн Засаг даргын зөвлөл, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн хуралд өргөн барьж, 77.5 хувийн хэрэгжилттэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд өргөн мэдүүллээ.

Д/д	Хэрэгжилт гаргасан заалтын тоо		24
1	Бүрэн хэрэгжсэн	□□□□□ □□□□□□□□□□□□	10
2	Хэрэгжих шатанд	□□□□□□□□□ □□□□□ □□□□□	11
3	Хэрэгжилт хангалтгүй	□□□□□□□□□□ □□□□□□□□ □□□□	3
4	Хэрэгжээгүй	□□□□□□□□□ □□□□	-
5	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	□□□□□□□□□ □□□□□□□□□□□□	-
Хэрэгжилтийн дундаж			77.5%

Санхүүгийн хяналт, дотоод аудитын чиглэлээр:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ЗДТГ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Засаг даргын тусгай сан, ОНХС, Төв Чандмань ДЭХГ-ын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Зуунмод сумын Бүжинхэн, Дэгдээхий, Ирээдүй, Унагалдайн андууд, Хүмүүн цэцэрлэгүүд, 4-р сургууль, 5-р сургууль, Хүмүүн цогцолбор цэцэрлэг, Бумбардай цэцэрлэг, Зуунмод сумын ЗДТГ, ИТХ, Соёлын төв, Хот тохижуулах газар, Баруун Зуунмод ББН өрхийн ЭМТ, Архуст, Баян, Баянжаргалан, Баянцогт, Аргалант, Лүн, Баянхангай, Угтаалцайдам, Цээл сумдын төсөвт байгууллагуудын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, Баянцагаан сумын ЭМТ, Мөнгөнморьт сумын ЗДТГ, Татварын хэлтэс, ОНХ-ийн сан, ЭЭС, Сумдын сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, өргөдлөөр аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тус тус хийж 5,469,928.6 төгрөгийн зөрчил илрүүлж 301,249.1 төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 1,981,689.8 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага, 3,186,989.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа. Өмнөх оны актын үлдэгдэл 171,193.5 мянган төгрөгөөс 66,469.3 мянган төгрөг, 2022 онд тогтоосон актаас 121,972.0 мянган төгрөг тус тус барагдсан байна.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө эхний 07-р сарын байдлаар орон нутаг 14204,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 13626,3 сая төгрөг төвлөрүүлж 95,9 хувьтай, 577,9 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 3041,7 сая төгрөг төвлөрүүлэхээс 4369,1 сая төгрөг төвлөрүүлж 143,6 хувьтай, 1327,3 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 1481,6 сая төгрөгөөр биелж, 107,4 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Батсүмбэр, Баяндэлгэр, Баянцогт, Заамар, Мөнгөнморьт, Эрдэнэ, Зуунмод зэрэг 7 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баян, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Лүн, Сүмбэр, Угтаал, Эрдэнэсант зэрэг 13 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Баянхангай, Бүрэн, Дэлгэрхаан, Өндөрширээт, Сэргэлэн, Цээл зэрэг 7 сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

2022 оны 7 сарын байдлаар нийт 38061,3 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг аймгийн төсөвт байгууллагууд болон 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

-Сумдын ИТХ,ЗДТГазрын зардал , ЕБС, СӨБ, ЭМТөв, Соёлын байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтэд 23305,0 сая төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 14756,3 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна

Өр, авлагын талаар:

2022 оны 7-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 158,2 сая төгрөгийн авлага, 417,3 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 276,8 сая төгрөг буюу 66,3 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 28,8 сая төгрөг буюу 6,9 хувь нь гэрэл цахилгааны өр, 54,5 сая төгрөг буюу 13,1 хувь нь тээвэр шатахууны өглөг, үлдсэн 57,2 сая төгрөг буюу 13,7 хувийг бусад өр эзэлж байна.

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/772 дугаар захирамжаар батлуулж төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн цахим тендер шалгаруулалтын www.tender.gov.mn системээр батлуулж тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг авсан. Батлагдсан төлөвлөгөөг нийтэд ил тод болгох ажлын хүрээнд www.shilendans.gov.mn, www.tov.gov.mn, www.khural.mn сайтуудад байршуулан ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 59.469.7 сая төгрөгийн 96 төсөл, арга хэмжээ тусган баталж үүнээс тендер шалгаруулалт зохион байгуулахаар 59,314.7 сая төгрөгийн 85 төсөл, арга байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 40.361.2 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ;
- Аймгийн Шилжих үлдэгдэлийн хөрөнгө оруулалтын 6.424.6 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ;
- Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтын 2.742.8 сая төгрөгийн 3 ажил;
- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5,504.3 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээ;
- Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1.206.9 сая төгрөгийн 6 ажил;
- Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 608.0 сая төгрөгийн 5 ажил;
- Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын 2022 оны эм, эмнэлгийн хэрэглэл худалдан авах 1.600.0 сая төгрөгийн бараа худалдан авах;
- Гадаадын хөрөнгө оруулалтын 867.0 сая төгрөгийн 1 ажил.

2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах зорилтын хүрээнд 8 дүгээр сарын байдлаарх худалдан авах ажиллагааны явцын мэдээлэл: Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ:

- 38,659.7 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалт явуулж, 9 төсөл, арга хэмжээнд 38,153.0 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр Жаргалант, Баянцогт сумын ЗДТГ-ын барилгын засвар, аймгийн МХГ-ын барилгын засварын хөрөнгө татагдсан тул тендер шалгаруулалтыг зогсоосон. Мөн Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг улсын хэмжээнд-8: Хориуд /Төв, Мөнгөнморьт сум/ -ыг тендер шалгаруулалтыг БОАЖЯ-аас түр зогсоосон байна.

2. Аймгийн шилжих үлдэгдээс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

- 17 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрхийг захиалагчдад хүргүүлснээс 16 төсөл, арга хэмжээнд 5,829.1 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. 2 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулагдах шатанд хүлээгдэж байна.

3. Аймгийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

- Замын сангаас 2,742.6 сая, төгрөгийн 3 ажлаас 2,222.6 сая, төгрөгийн төсөвтэй 2022 онд 190.0 сая, төгрөгийн ажил гүйцэтгэх 1 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулагдсан. 2 төсөл арга хэмжээ гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлээд байна.

4. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

- 3,249.4 сая, төгрөгийн 25 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулах эрхийг олгосноос захиалагч 2,631.2 сая, төгрөгийн 24 ажилд гэрээ байгуулсан. Зуунмод хотын 1, 2-р хэсгийн

халаалтын зуухыг шинэчлэх ажлын тендерийн нээлтийг 8 сарын 08-нд хийж, 19-нд гэрээ байгуулах эрхийг Эрчимдөл ХХК-д олгосон.

- Сумын түвшинд үнэлгээний хороо үнэлгээ хийж буй 200.0 сая, төгрөгийн 1 ажил.

- Сумдын түвшинд зарласан 150.0 сая төгрөгийн 1 ажил байна.

-Тендер зарлахаар хүлээгдэж буй, ажлын даалгавар, техникийн доторхойлолт, зураг, төсөл, үнэлгээний хороо байгуулагдаагүй 160.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ байна.

5. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

- Нийт 1,206.9 сая, төгрөгийн 6 төсөл, арга хэмжээнд 100 хувь тендер зарлаж, 8 сард тендерийн нээлт хийх 283.0 сая, төгрөгийн 1 ажил байна. Захиалагч байгууллагад 923.9 сая төгрөгийн 5 ажилд гэрээ байгуулах эрх олгосноос 5 ажилд 894.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна.

6. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-Нийт 608.0 сая, төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас гэрээ байгуулагдсан 244.0 сая, төгрөгийн 3 ажил, хэлэлцээр хийгдэж буй 300.0 сая төгрөгийн 1 ажил байна. Захиалагчийн шийдвэрээр 64.0 сая төгрөгийн 1 ажилд гэрээ байгуулагдсан.

7. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын эрүүл мэндийн төвийн 2022 онд шаардагдах: 1 төсөл, арга хэмжээ-дотроо нийт 32 багцтай 1,600.0 сая, төгрөгийн төсөвт өртөгтэй бараа худалдан авах тендерийг зарлаж 32 багцад шалгаруулалт хийж, гэрээ байгуулагдсан.

8. Гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

- Япон улсын хөрөнгө оруулалтаар Хүмүүн цогцолбор сургуулийн барилгын дотор засварын ажлын тендерийг 2 дахь удаагаа зарлаж, нээлтийг 2022.07.18-нд зохион байгуулсан. Гэрээ байгуулах эрхийг Шинэчлэл Инвест ХХК-д 8 сарын 8-нд олгосон

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын нэгдсэн программд 2022 оны 08 дугаар сарын 26ны өдрийн байдлаар нийт 228 байгууллага хөрөнгийн бүртгэл ирүүлэхээс 155 байгууллагын тайлангаа баталгаажуулж, 38 байгууллагын тайлан засвартай тул буцаагдаж, тайлангаа хугацаандаа илгээгүй 35 байгууллагын удирдлагуудад албан шаардлага хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13,2021 онд 1 өрх нийт 26 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулснаар сарын төлбөрийг график хугацааны төлөлттөнд хяналт тавьж ажилласнаар 2022 оны 08 сарын байдлаар 26 айлын түрээсийн төлбөр 25,416,015 төгрөг төвлөрүүлсэн байна. Мөн түрээсийн орон сууцанд хамрагдахаар өргөдөл гаргасан 85 иргэнтэй утсаар холбогдох Түрээслээд өмчлөх орон сууцны журмын хүрээнд урьдчилгаа 30%-ийг төлөөд хамрагдах талаар мэдээллийг өгч боломжгүй гэсэн тохиодолд өргөдлийг хаасан тухай мэдэгдэж байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 11 дүгээр хуралдаанаар Сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай, Сэргэлэн, Мөнгөнморьт сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай асуудлуудыг бэлтгэн хурлаар өргөн барихад бэлэн болоод байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт Хөшигийн хөндийн шинэ суурьшлын бүсэд дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил 2022 оны 08-р сарын 12 нд барилгын шав тавих ёслолыг хийж ажлыг эхлүүллээ.

Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2022 онд 58 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталсан ба энэ сард 9 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон.

Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах, ерөнхий төлөвлөгөө батлах, ажлын хүрээнд 2022 онд 101 зураг төсөл зөвшөөрөлцсөн. Энэ сард 4 зураг төсөл батлаад байна.

Барилга, инженерийн байгууламжийн зураглалыг шалгаж, хот байгуулалтын мэдээллийн санд мэдээлэл бүрдүүлэх ажлын хүрээнд 2022 онд 56 инженерийн байгууламжийн зураглалыг

оруулсан.Энэ сард 4 инженерийн байгууламжийн зураглалыг мэдээллийн санд хүлээн авч акт олгосон.

“Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон ашиглалтад оруулах” хүрээнд :

- Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 13 барилга байгууламж болон гадна цахилгаан хангамжийн ажлуудад олгосон.

- Барилга байгууламж ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд 6 иргэний гадна цахилгаан хангамжийн ажлыг байнгын ашиглалтад оруулсан.

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа Эрдэнэсант сумын 4 байршилд, Алтанбулаг сумын 3 байршилд нийт 7 нэгж талбарын газрын дуудлага худалдааны зарыг www.mle.mn сайтад баталгаажуулсан.

2022.08.28 өдрийн байдлаар газрын төлбөрийн орлогоос 1532,2 сая төгрөг аймаг сумын дансанд төвлөрүүлсэн байна. 2023 оны газрын төлбөрийн төлөвлөгөөний төслийг 27 сумдаас авч нэгтгэн Сангийн яаманд 2,9 тэрбум төгрөгөөр хянуулаад байна.

Газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг Газрын мониторингийн цахим системээр хүлээн авч баталгаажуулан ажиллаж байна. 08 сарын байдлаар 180 мэдэгдэл хуудас хэвлэж өгсөнөөс 140 хянан баталгааг цахимаар ирүүлсэн байна. Үүнээс: баталгаажуулсан төлөвтэй 132, Илгээх буюу шинээр ирүүлсэн 7, хянасан буцаасан төлөвтэй 1 тайлан тус бүр байна.

Аймгийн нутаг дэвсгэрт газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгаа хийж байгаа тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудад заавар зөвлөгөөг өгч шаардлага хангаагүй засварлах шаардлагатай 17 тайланг буцаан засвар хийлгэн цахим системээр баталгаажуулан ажиллаж байна.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ургацын штабыг аймгийн Засаг даргын 8 дугаар сарын 23-ны өдрийн А/479 тоот захирамжаар байгуулж, ургац урьдчилсан баланс тогтоох ажлын хэсэг 19 суманд ажиллаж, таримал ургамлын ургалтын нөхцөл байдалтай танилцаж, ургац хураалтын бэлтгэл ажлыг эрт оновчтой зөв хангуулах, хураалтыг технологит хугацаанд нь зохион байгуулах талаар сумдын удирдлага, мэргэжилтэнүүдэд үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Ургацын урьдчилсан балансаар нийт 304438.9 тн ургац хураан авах төлөвтэй байна. Үүнд:

- Үр тариа 58564 га талбайгаас 83193.9 тн, нэгжийн ургац 14.2 цн,
 - үүнээс улаанбуудай 51175 га талбайгаас 71485.2 тн, нэгжийн ургац 14.0 цн
- Төмс 125525.9 га-с 153915 тн, нэгжийн ургац 122.9 цн
- Хүнсний ногоо 1923.6 га-с 23893.4 тн, нэгжийн ургац 124.2 цн
- Таримал тэжээл 17229 га-с 32857 тн, нэгжийн ургац 19.1 цн
- Тосны ургамал 27955 га -с 10580 тн, нэгжийн ургац 3.8 цн

Уринш, ургац хураалтын шатахууны хөнгөлөлтөд хамрагдах 14 сумын 1917 иргэн, аж ахуйн нэгжийн судалгаа, ургац хураалтын үед ажиллах хүчний судалгааг ХХААХҮЯаманд хүргүүлж, 3 сургуулийн 1200 оюутан ажиллах гэрээ хийгдээд байна.

Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/452 тоот захирамжаар сумдын өвс тэжээлийн нөөц бэлтгэх чиглэл хүргүүлж ажиллалаа. Аймгийн хэмжээнд 3 суманд 10 хадлангийн салаа ажлаа эхлээд байна

Төв аймгийн Засаг дарга санаачлан аймгийн ЗДТГазар Батсүмбэр сумын ЗДТГ, ХХААГ, СХЗХ, Монголын үхэр үржүүлэгчдийн нэгдсэн холбоо, аймгийн Баялаг бүтээгдчийн холбоо, Үндэсний томоохон үйлдвэрлэгч АПУ, Сүү ХК, Витафит компаниудтай хамтран анх удаа “Төв түмний сүүн соёл” Сүүний баяр-2022 арга хэмжээг Батсүмбэр суманд зохион байгуулж, 16 сумын 17 багийн 150 гаруй үхрийн аж ахуй эрхлэгчид, саальчид, хоршооллын төлөөлөл оролцож “Шилдэг саальчин”, “Шилмэл мал”, “Сүүн ашиг шим ихтэй үнээ”, “Нутгийн цай-Цагаан зоог”, “Уламжлалт цагаан идээ” “Саальчид дуулж байна” “Шилдэг сум” 7 төрлөөр 35 номинацид өрсөлдөж шилдгүүдээ шалгарууллаа.

Баян-Өнжүүл, Бүрэн суманд Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөртэй хамтран зохион байгуулж явуулын ахуй үйлчилгээд 160 иргэн, мэргэжил дээшлүүлэх сургалтад 40 гаруй иргэн хамрагдаж, үсчин, маникюр, цахилгаан засварын үйлчилгээ үзүүллээ.

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн Засаг даргын А/122 тоот захирамж, газрын даргын А/13 тоот тушаалаар Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1585.0 мян.тол мал хамруулахаар төлөвлөн Биокомбинат ТӨХХК-тэй гэрээ байгуулан эм биобэлдмэлийн татан авалт 100.0%, дархлаажуулалт 97.1 хувьтай хэрэгжиж дууссан.

Баянжаргалан сумын Буурын ухаа гэх газарт зусаж буй малчин иргэн Г.Адъяагийн суурьт оношлогдсон хонины цэцэг өвчний үед хэрэгжүүлсэн хорио цээр, хязгаарлалтын дэглэм 2022 оны 08 дугаар сарын 13-ны өдөр цуцлагдаж энгийн дэглэмд шилжин эцсийн халдваргүйтгэл хийгдлээ.

2022 оны 8 дугаар сарын 11-ны өдөр Баянцагаан сумын “Зүүн бууц” гэх газарт зусаж буй малчин иргэн Ё.Мөнхбаярын сууриас, 8 дугаар сарны 17-ны өдөр Баян-өнжүүл сумын холбоо гэх газарт зусаж буй малчин иргэн Ч.Батцэнгэлийн сууриас, 8 дугаар сарын 17-ны өдөр Алтанбулаг сумын хайрхан бүрд гэх газарт зусаж буй малчин иргэн Л.Булганы сууриас тус тус дуудлага ирсний дагуу очиж үзлэг хийн дээж авч УМЭАЦТЛ-т илгээхэд гоц халдварт Бог малын мялзан өвчин оношлогдон хорио цээрийн дэглэмийг тогтоон ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 3 сумын 4 голомтод 6 өрхийн 237 мал өвчилж үүнээс 61 хорогдож 168 малын шинж тэмдэг арилж, 8 мал эмчилгээтэй байна. Гоц халдварт бог малын мялзан өвчин 3 суманд оношлогдсон тул аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/482 тоот захирамжаар Хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж байна.

Мөн улсын хэмжээнд гоц халдварт өвчний гаралт нэмэгдэж байгаа тул аймгийн Засаг даргын 2022 оны 08 сарын 23-ны өдрийн А/477 тоот захирамжаар гадны аймаг, сумаас амьд мал авахыг хориглож 21 аймагт мэдээллийг цахимаар хүргүүлсэн. Газрын даргын 206 тоот албан бичгээр 27 суманд гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх албан бичгээр чиглэл хүргүүлж байна.

Аймгийн Онцгой комиссын хурлаар гоц халдварт өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл хийж аймгийн Засаг даргын А/476 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулан гоц халдварт өвчин бүртгэгдсэн сумд болон дархлаажуулалтын ажил хийж буй сумдад хяналт шалгалт хийхээр томилоод байна.

Мал эмнэлгийн арга хэмжээний хэрэгжилт, гоц халдварт өвчний нөхцөл байдлын талаарх 27 сумтай цахим хурал хийж 32 албан хаагч оролцлоо.

Монгол улсын шадар сайд, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд нараас чиглэл өгсний дагуу сумдад өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулахаар ажиллаж байна.

Малын эрүүл мэндийн үзлэгт 4100.0 мян.тол мал хамруулахаас 2785.5 мян.тол мал хамруулж 67.9 хувьтай, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 7943.2 мян.тол мал хамруулахаас 4493.6 мян.тол мал хамруулж 56.5 хувьтай, 1350 мян.м2 талбайд халдваргүйтгэл хийхээс 1127.6 мян.м2 талбай буюу 83.5 хувьтай тус тус хэрэгжиж байна.

Аймгийн Засаг даргын А/468 тоот захирамжаар 5 суманд бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг эхлүүлэн өнөөдрийн байдлаар 357.6 мян.тол мал хамруулж 51.61 хувьтай явагдаж байна.

Бруцеллээс өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын удирдамжийг аймгийн Засаг даргын А/449 тоот захирамж, газрын даргын А/43 тоот тушаалаар сумдад хүргүүлэн, 88 МЭҮН-д батлагдсан хуваарийн дагуу олгоод байна. Өнөөдрийн байдлаар дархлаажуулалт 362.0 мян.тол мал хамруулж 31.9 хувьтай явагдаж байна.

Тайлант хугацаанд 16499 мал, амьтан, 189.4тн мах, махан бүтээгдэхүүн, 895 ширхэг арьс шир, 369.4тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 536.5тн ноос, 1.4тн айраг, 7.4кг дайвар бүтээгдэхүүнд 3137 мал эмнэлгийн гэрчилгээг олгож, 16 дуудлагын дагуу 89 малд үйлчилгээ үзүүллээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг нь 3 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа 1656 тээврийн хэрэгсэл, адуу 1274, үхэр 1033, хонь 10441, ямаа 5730, тэмээ 61 нийт 18539 толгой мал, 2041 мян.тн мах, махан бүтээгдэхүүн,

ноолуур 5350 кг, арьс 595 ширхэг, дайвар бүтээгдэхүүн 19,8 тн, сүү сүүн бүтээгдэхүүн 167.9 литр, өндөг 527760 ширхэг, зөгийн бал 350 кг бүтээгдэхүүнд эрүүл ахуйн үзлэг хийн, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж ажиллалаа.

“Ногоон хөгжил-баялаг бүтээгчдийг дэмжих” урианы жилийн ажлын хүрээнд Архуст, Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Баяндэлгэр, Мөнгөнторьт суманд фермерийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн саалийн үнээ, бухнаас, малаас хүнд дамжин халдварладаг зооноз бруцеллөз өвчний шинжилгээг үнэ төлбөргүй хийх талаар чиглэл өгч Баянчандмань сумаас 153 дээж, Баяндэлгэр сумаас 150 ийлдсийн дээж ирж шинжилгээ хийхэд сөрөг урвал үзүүлээ.

Баянцагаан сумаас Зуунмод суманд ирсэн 395 хуцнаас цусны дээж авч БММ, Шүлхий, Бруцеллөз өвчний шинжилгээнд хамруулахаар УМЭАЦТЛ- хүргүүлсэн. Няан судлалын шинжилгээнд Сэргэлэн, Зуунмод сумдаас ДХХ өвчний шинжилгээнд дээж ирүүлэн шинжлүүлэхэд эерэг урвал, Баян-Өнжүүл сумаас Цусан халдварт өвчний шинжилгээнд дээж ирүүлэн шинжлүүлэхэд эерэг урвал үзүүлсэн.

Ариун цэвэр, магадлан шинжилгээгээр 11 сумын цэцэрлэг, сургуулийн хэрэгцээнд нийлүүлэгдэж буй 5 махны дээжинд антибиотикийн үлдэгдэл, 10 сүүнд бруцеллөзын шинжилгээ хийхэд бүгд сөрөг дүн үзүүлсэн.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тохирлын үнэлгээг Батсүмбэр, Баянчандмань, Мөнгөнморьт, Сэргэлэн, Зуунмод, Эрдэнэ сумдын худалдаа, үйлчилгээний цэг, бүтээгдэхүүний үнэлгээ хийж, 46 аж ахуйн нэгж, иргэний тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгох, сунгах үйлчилгээ үзүүллээ. Хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын чиглэлээр: Батсүмбэр, Зуунмод, Мөнгөнморьт сумын айл өрх, худалдаа, үйлчилгээний газрын цахилгаан, массын хэмжлийн 365 ширхэг хэрэгсэл шалгаж баталгаажууллаа.

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжын дагуу Эрдэнэ, Баянжаргалан, Баян, Сэргэлэн, Баянцагаан, Заамар сумдад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн аж ахуй нэгж байгууллага, бичил уурхай эрхлэгч, нөхөрлөлүүдэд 8сарын 2-5, 8сарын 15-18ны өдрүүдэд хяналт шалгалт хийлээ. Тус хяналт шалгалтаар 8 нөхөрлөл, 32 ААН хамрагдсан бөгөөд 2 нөхөрлөл, 5 ААН-ийн үйл ажиллагааг зогсоож, зөрчлийг арилгуулж байж ажиллуулахаар боллоо.

Нөхөн сэргээлт 2024 арга хэмжээний хүрээнд БОАЖ-ын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг 08 сарын 22ны өдөр Заамар суманд ажиллаж, уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалж эвдэрсэн 120 га талбайд нэр бүхий 17 ААН нөхөн сэргээлтийн ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулах үүрэг өгсөн. Энэхүү үүргийн дагуу БОАЖГ, МХГазрын хамтарсан ажлын хэсэг Заамар суманд үйл ажиллагаа явуулж буй ААН-дэд дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг хийлгэхээр 08сарын 25-ны өдрөөс тус суманд ажиллаж байна.

Байгаль орчны эсрэг 9 зөрчил илэрсэнийг холбогдох арга хэмжээ авах зөрчлийг таслан зогсоох тухай БОАЖГ-ын даргын 2022 оны 08 дугар сарын 24-ны өдрийн 07/273 албан бичгээр Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж ажиллаа.

Байгаль орчин аялал жуулчлалын яам, Аймгийн Засаг даргын тамгийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтийн газар, ХХҮГ-ийн хамтарсан ажлын хэсэг Сэргэлэн сумын 1-р багийн иргэдийн нийтийн хуралд оролцсон. Энэхүү хурлаар Сэргэлэн сумын 1-р багийн нутагт аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулах газрыг улсын тусгай хэрэгжээнд авах тухай төслийн танилцуулгыг хийж, иргэдээр хэлэлцүүлж, иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг Сэргэлэнд сумын Засаг даргад хүргүүлээд байна.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, “Бөмбөрцгийн сүмбэ хүүхдийн байгууллага” ТББ-аас зохион байгуулж буй “Аюулыг авдарлая” тамхины иш цуглуулах улсын уралдаан Төв аймагт 08 сарын 25-наас 09 сарын 15-ны хооронд зохион байгуулахаар зарлаад байна. Иргэдийн эрүүл аюулгүй, таатай орчинд амьдрах орчин нөхцөлийг хангах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах зорилгоор маш нарийн хуванцараар хийгддэг аюултай хог хаягдлын нэг болох тамхины ишийг цуглуулах уралдааныг аймгийн хэмжээнд 27 сумыг хамруулан шилдгийг тодруулан, улмаар улсын уралдаанд оролцохоор төлөвлөөд байна.

2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Заамар сумын Хайлааст 3-р багт Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгөөр байгаль орчны салбарын хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл хийж, иргэдийн зүгээс сонирхсон асуултад хариулж, гарын авлага тараан ажиллав. Мөн аймгийн ховор ан бүхий бүс нутгийг орон нутгийн хамгаалалтанд авах тухай тогтоолын төсөл болон нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф тогтоох тухай журмын төслийг иргэдэд танилцуулан, нээлттэй сонсголыг зохион байгууллаа.

Тус өдөрлөгт Хайлааст 3-р багийн иргэн Сум хөгжүүлэх сангийн 8 сая төгрөгний зээлээр дахивар хог хаягдлыг шатах төхөөрөмж худалдан авч, хог хаягдлыг хуримтлуулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах үйл ажиллагааг эрхэлж, 10 тонн гаруй хог хаягдлыг Улаанбаатар хотын дахивар худалдан авах цэгт нийлүүлсэн байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яам, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессийг боловсронгуй болгох үндэсний чадавхийг бэхжүүлэх төсөл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газраас хамтран зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох үндэсний зорилтыг бүс нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах нь” сургалт зөвөлгөөн зохион байгуулагдаж, 10 хүний бүрэлдэхүүнтэй энэхүү зөвөлгөөнд оролцсон.

Төв аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын хяналт, шалгалт хийх удирдамжын дагуу Баяндэлгэр, Борнуур, Заамар, Эрдэнэ, сумдад шалгах, зөвлөн туслах зорилгоор ажиллаа. Борнуур суманд Байгаль хамгаалагчын ажил үнэт цаас, эрхийн бичиг бичэлтэнд үзлэг шалгалт хийлээ.

Мөн Эрдэнэ, Баяндэлгэр, сумдад хяналт шалгалт, үрийн нөөц тогтоохоор ажиллав. Баяндэлгэр суманд хууль бус мод бэлтгэл, гарал үүсэлийн бичиггүй мод бэлтгэсэн иргэнийг зогсоон сумын БОХУБ-д хүлээлгэн өглөө.

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм, өдөр тутмын цаг агаарын мэдээ, цаг агаарын аюултай үзэгдлээс анхааруулах мэдээ 4 удаа гаргаж Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд и-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна. Цаг агаарын аюултай үзэгдлээс анхааруулах болон сэрэмжлүүлэх мэдээг “Багц мессеж”-ээр Аймгийн онцгой комисс, Сэргэлэн, Зуунмод, Баянчандмань сумдууд болон хойд талын нутгийн 1808 хэрэглэгчдэд хүргэж ажиллалаа.

Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 08 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар нийт 36 удаа ажиглалт хийсэн ба хүхэрлэг хийн дундаж агууламж 0.003 мг/м^3 азотын давхар ислийн дундаж агууламж 0.006 мг/м^3 үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүхэрлэг хийн дундаж агууламж 0.002 мг/м^3 -ээр буурсан, азотын давхар ислийн дундаж агууламж 0.001 мг/м^3 -ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 08 дугаар сард Туул-Лүн, Шивэрт-Борнуур голуудын хяналт шинжилгээг хийхэд цахилгаан дамжуулах чанар нь Туул-Лүн 159 uS/cm , Шивэрт-Борнуур 339 uS/cm , тус тус гарлаа.

Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2022 оны 08 дугаар сарын 21-ний байдлаар усны түвшин: Хэрлэн гол Хэрлэн-Хонгон 178 см , Хэрлэн-Мөнгөнморьт 190 см , Туул гол Туул-Алтанбулаг харуулд 619 см , Туул-Лүн харуулд 178 см , Туул-Заамар харуулд- 212 см , Сөгнөгөр-Сөгнөгөр 208 см , Шивэрт-Борнуур 137 см тус тус байсан ба өмнөх оныхтой харьцуулахад усны түвшин Хэрлэн голын дагуух Хэрлэн-Хонгон, Хэрлэн-Мөнгөнморьт харуулууд $45\text{-}50 \text{ см}$ их, Туул голын дагуух Туул- Алтанбулаг, Туул-Лүн харуул, Туул-Заамар харуулууд $5\text{-}52 \text{ см}$ их, Сөгнөгөр голын дагуух Сөгнөгөр-Сөгнөгөр харуул 5 см бага, Шивэрт голын дагуух Шивэрт-Борнуур харуул 3 см их байна. Цаашдаа хур бороо их орж голуудын усны түвшин ихэссэн үерлэх тул тариаланчид, аж ахуйн нэгж байгууллага, ард иргэд үерийн аюулаас байнга сонор сэрэмжтэй байхыг онцгойлон анхааруулж байна.

ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын ивээл дор төв аймгийн “Багшийн тасралтгүй хөгжил-зөвлөх багш нарын манлайлал” сургалт, зөвлөгөөнийг 08 дугаар сарын 29-ны өдөр БШУЯ, БШУГ-тай хамтран зохион байгуулж, сургалтад 27 сумын 200 гаруй багш оролцлоо. “Оюунлаг Төв аймаг” хөтөлбөрийн хүрээнд Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан 10 багшид тус бүр 1 сая төгрөг, тив дэлхийн спортын тэмцээн уралдаанд амжилт гаргасан 5 сурагч, бэлтгэсэн 3 дасгалжуулагч багш нарт нийт 5,4 сая төгрөгийн урамшуулал олгосон.

Хөдөлмөрч манлай ахмад шалгаруулж шагнах журмыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, шинэчлэн баталлаа.

Монгол Улсын анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төгсөгчдийн багш шавийн уулзалт арга хэмжээний үеэр АШУҮИС-тай хамтын ажиллагааны гэрээ үзэглэх арга хэмжээ зохион байгуулан, аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, АШУҮИС-ийн төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга Б. Дамдиндорж нар хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.

Мөн аймаг орон нутгийнхаа хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн багш нарыг орон нутгийн шагналаар шагнаж, урамшууллаа. Үүнд: Аймгийн ИТХ-ын “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ээр МУ-н төрийн соёрхолт, хүний гавьяат эмч, ЭМЯ-ны мэс заслын ерөнхий мэргэжилтэн, АШУҮИС-ийн мэс заслын тэнхимийн зөвлөх, АШУ-ны доктор, профессор О.Сэргэлэн, Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр АШУҮИС-ийн уушги, харшил судлалын тэнхимийн зөвлөх, АУ-ны доктор, профессор С.Мөнхбаярлах нарыг тус тус шагналаа.

Зорилтот бүлгийн өрхийн ая тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор “Гэр төсөл” хэрэгжүүлэн, аймгийн Засаг дарга, Зүүнсайн ХХК-тай 30 гэр нийлүүлэх гэрээ байгууллаа.

Хичээлийн шинэ жилийг угтан бэлтгэл ажлыг хангаж, сургалтын байгууллага, ЭМГ,МХГ,ЦГ зэрэг салбар дундын уялдааг хангаж ажиллах талаар Засаг даргын албан даалгавар гаргаж хүргүүллээ.

“Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил-зөвлөх, тэргүүлэх багш нарын манлайлал” сургалт, багш нарын бага хурлыг зохион байгуулж, ЭЕШ-ын судлагдахуунаар тэргүүлсэн 10 багшийг аймгийн Засаг даргаас 10.0 сая төгрөгөөр, тив, дэлхийн спортын тэмцээнээс мөнгө, хүрэл медаль хүртсэн 5 сурагч, бэлтгэсэн 3 багшийг 5.4 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Нэгдүгээр ангитай ажиллах багшид сурагчийн онцлогийг ойлгон сургуульд элсэн ороход шаардлагатай чадвар, дадал, хандлага эзэмшсэн байдлыг тогтоож, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Нэгдүгээр ангийн сурагчтай ажиллах арга зүй” багшид арга зүйн дэмжлэг үзүүлэх үндэсний сургалт 8-р сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байна. Сургалтад 30 сургалтын менежер, 68 багш 65 хөгжим, биеийн тамирын багш нийт 163 хүн оролцож байна.

Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээг 2022-2023 оны хичээлийн жилээс төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид элсэн суралцаж буй бүх суралцагчийг хамруулан 2022 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс 2022 оны 10-р сарын 07-ны өдрийн хооронд үндэсний хэмжээнд зохион байгуулахаар болж судалгаа зохион байгуулах арга аргачлалд бэлтгэх зорилгоор цахим сургалтын бэлтгэл ажлыг хангаж байна.

Мөнгөнморьт сумын 75 хүүхдийн дотуур байрны барилгын ажлын гүйцэтгэлтэй улсын комисс танилцлаа. 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Улсын комисс ажиллаж, гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээж авлаа. Гүйцэтгэгч: Хоргын тогоо ХХК.

“Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нийгмийн ажилтнуудын цахим сургалт, зөвлөгөөн”-д 2022 оны 08 дугаар сарын 25-нд 27 сумын ЕБС, ПК, МСҮТ-ийн нийгмийн ажилтнуудыг хамрууллаа.

“Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил-зөвлөх багшийн манлайлал” үндэсний сургалт, зөвлөгөөнд БШУГ-ын дарга, мэргэжилтэн, зөвлөх багш нар нийт 18 хүн хамрагдлаа.

2022-2023 оны хичээлийн жилийн I-V-р ангийн сурах бичгийн түгээлтийн хуваарь гаргаж, Ерөнхий боловсролын сургуулиудад сурах бичгийн түгээлт явагдаж байна. Мөн сургуулийн захирал, менежерүүдэд цахим хурлаар сурах бичгийн хэвлэлт, түгээлтийн хугацаа, төлбөртэй сурах бичгийн талаарх мэдээлэлийг хүргэсэн.

Цээл сумын 70 хүүхдийн дотуур байранд ариун цэврийн байгууламж, 2 душны өрөө, 10 ариун цэврийн суултуур хийгдэж, 08 дугаар сарын 18-ны өдөр Улсын комисс хүлээж авч, ашиглалтад орлоо. Гүйцэтгэгч: Винтер гарденХХК. БЕГ-аас Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүлээн авч, ЕБС, цэцэрлэгүүдэд хүлээлгэн өгсөн.

Төрийн болон төрийн бус өмчийн хэлбэрийн 31 сургууль, 40 цэцэрлэг, албан бус насан туршийн боловсролын төвийн 2023 оны төсвийн төслийг авч нэгтгэн Боловсролын ерөнхий газарт хүргүүлсэн.

2022.08.09-08.10ны өдрүүдэд Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалт хэрэгжилт зохицуулалтын газартай хамтран Бүрэн, Лүн, Заамар, Заамар Хайлааст баг, Угтаалцайдам, Цээл, Жаргалант сумын шинэ барилга болон ариун цэврийн байгууламжийн гүйцэтгэлийн явцтай очиж танилцсан.

- Бүрэн сургууль -90%
- Бүрэн дотуур байр- 5%
- Лүн цэцэрлэг-60%
- Заамар сургууль-90%
- Заамар Хайлааст багын сургууль-20%
- Угтаалцайдам цэцэрлэг-35%
- Цээл ариун цэврийн байгууламж-90%
- Жаргалант ариун цэврийн байгууламж-75%
-

СОЁЛ, УРЛАГИЙН ХҮРЭЭНД:

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Сайханы Саравч хөндийд 12-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Нүүдэлчин Монгол-2022" дэлхийн соёлын фестивалд аймгийн 22 сумын 56 өвлөн уламжлагчийн бэлтгэлийг хангаж оролцлоо. Аймгийн ЗДТГ, Монгол туургатан театр, аймгийн Музей, Нийтийн номын сан, 27 сумын Соёлын төв, аймгийн Тогоочдын холбоо зэрэг байгууллагууд хамтран ажиллаа. МУУГЗ Ш.Аюуш ерөнхий найруулагчаар ажиллаж, 21 аймаг, нийслэл нийт 22 багаас 565.2 оноогоор аймаг 10 дугаар байранд шалгарсан. Горхи-Тэрэлжийн байгалийн үзэсгэлэнт газар болсон "Нүүдэлчин Монгол-2022" соёлын биет бус өвийн их наадмын хүндтэй зочид ахмад настан, буурлууд байсан.

21 аймаг, нийслэлээс хуран цугларсан 1300-аад өвлөн уламжлагчдаас хамгийн ахмад өвлөн уламжлагчдаа талархал илэрхийлж, хүндэтгэл үзүүллээ. Ахмад өвлөн уламжлагчаар Төв аймгаас:

- Эрдэнэсант сумын сумын өв уламжлагч Ё. Дашзэвэг 87 настай

- Баянжаргалан сумын өв уламжлагч Хөдөлмөрийн баатар Х. Рэнцэндорж 87 настай ахмад өвлөн уламжлагч "Мал маллах арга ухаан" ай савын төрлөөр контент бэлтгэн оролцож, хамгийн ахмад өвлөн уламжлагчаар шалгарч, "Батламж" мөнгөн шагнал, мөн "Нүүдэлчин Монгол-2022" Соёлын биет бус өвийн их наадмын уламжлалт гар урлалын төрлөөр шалгарсан 7 сумын 9 өвлөн уламжлагчдын бүтээлийн үзэсгэлэн, урчуудын сурталчилгааг зохион байгуулан наадамчин түмэнд сурталчилан үзүүлж, "Шилдэг гар урлал, үзэсгэлэн" 5 багийн нэг болон шалгарч "Батламж" 1 сая төгрөгөөр шагнууллаа.

Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулсан "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого-2022"-ыг зохион байгуулах цахим сургалтад хамрагдаж, аймгийн нутаг дэвсгэр дэх 471 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын улсын тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.

Өндөрширээт сумын Соёлын төвөөс "ТАМГАНЫ БАЯР"-ыг санаачлан 08 сарын 19-нд амжилттай зохион байгуулан, 4 багийн нийт 220 гаруй малчин өрх оролцлоо. Ширмэл цагаан эсгий ширдэг дээр нийт 150 орчим унаганы тамга дарагдсан бөгөөд тамганы бүртгэл хийн БАТЛАМЖ олгосон. Дааганы уралдаан, Бөхийн барилдаан, Дэмбээ, Хуруу гаргах, Шилмэл эх мал, Шилмэл эцэг мал шалгаруулах уралдаанууд зохион байгуулагдсан. Уг арга хэмжээнд нийт 2.8 сая төгрөгийн зардал гарсан байна.

Алтанбулаг суманд 24-ний өдөр зохион байгуулагдсан "Хатантуулын бүсгүйчүүд-2022" арга хэмжээнд Баян-Өнжүүл, Өндөрширээт, Лүн, Алтанбулаг сумдын эмэгтэйчүүд Монгол дээл оёх, дээс томох, эсгий хийх, гар урлал, ээсгий ширдэг хийх, Монгол хоол цай хийх, сайхан Монгол бүсгүй шалгаруулах зэрэг төрлүүдэд амжилттай оролцлоо.

Энэ жилийн арга хэмжээ өмнөх жилээс өргөн цар хүрээтэй болж, эмэгтэйчүүд маш идэвхитэй оролцож, уламжлалт өв соёлыг сурталчлахын зэрэгцээ багаар ажиллахад үр дүн, амжилт хэрхэн гардаг гэдгийг харуулж чадлаа. Мөн энэхүү арга хэмжээнд зориулан сумын Засаг дарга яруу найрагч Батсуурь, хөгжмийн зохиолч О.Эрдэнэ нарын зохиосон “Хатан туулын бүсгүйчүүд” дууг хэн сайн дуулах вэ дууны уралдаан зохион байгуулан, эхний 3-н байр шалгаруулан шагнаж урамшууллаа. Арга хэмжээнд нийт 400 гаруй иргэд хамрагдсан.

“Төв түмний сүүн соёл” саальчдын баяр 08 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Батсүмбэр суманд зохион байгуулагдаж, аймаг, сумын удирдлагууд, Монгол Туургатан театрын уран бүтээлчид, сумын Соёлын төвийн уран сайханчид, 17 сумын саальчид, нийт 200 гаруй хүн хамрагдлаа.

Аймгийн Нийтийн номын сан:

08 дугаар сард танхимаар 26 байнгын уншигч, 95 үйлчлүүлэгч, нийт 195 уншигчдад ном олгож үйлчилсэн. “Номын сайн нөхөр” уралдаанд 1-6 дугаар ангийн сурагчдын заавал унших ном зохиолоор үзэсгэлэн гаргалаа.

“Цахим мэдээллийн танхим”-аас Солонгос хэлний анхан шатны сургалтыг дунд ахлах ангийн хүүхдүүдийн дунд 10 удаагийн хичээлийг үнэ төлбөргүй явуулж, уншигч хүүхэд залуучууд, иргэдэд зориулан заавал унших ном, үлгэр болон мэдээ мэдээллийг Facebook page цахим хуудсанд 102 мэдээ мэдээллийг байршуулан олны хүртээл болгож 24,466 хандалт авсан байна.

Аймгийн Музей:

Музейгээр нийт 1782 иргэн үйлчлүүлсэн. 2022 онд сумын хамгаалалтад авах дурсгалын жагсаалт, албан тоотыг Соёлын өвийн тухай хуулийн дагуу мэргэжлийн байгууллагын санал дүгнэлт авах, солбицолын цэг, талбайн хэмжээ тогтоолгох зорилгоор Соёлын өвийн үдэсний төв, ШУА-ийн Археологийн хүрээлэн, аймгийн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД:

2022-2023 оны хичээлийн шинэ жил эхлэж байгаатай холбогдуулан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ MNS 6781:2019” стандарт, “Хүүхдийн тоглоомын талбай MNS 6751:2019” стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч нарт хугацаатай зөвлөмж хүргүүлсэн. “Нэгдүгээрт хүүхэд” нөлөөллийн аяны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

27 сумын хэмжээнд 21 удаагийн уралдаан сунгаа, үсэргээ болж давхардсан тоогоор 493 хүүхэд оролцсоноос 4 хүүхэд мориноос хөнгөн унаж, бэртэл аваагүй байна.

Наймдугаар сард Хүүхдийн тусламжийн утас 108-д 13 мэдээлэл бүртгэгдсэнээс:

- Бие махбодийн хүчирхийлэл-4
- Үл хайхрах -3
- Сэтгэл санааны хүчирхийлэл-4
- Өргөдөл, гомдол-2 дуудлага байна. Үүнээс 3 дуудлага хаасан, бусад дуудлагад хариу үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

“Олон улсын аавуудын өдөр”-ийн хүрээнд 08 дугаар сарын 08-ны өдөр “Сэтгэлийн гал” уулзалт, өдөрлөгийг Баян суманд байрлах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 415 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 322 хүмүүжигч нарт зохион байгуулан, хүмүүжигч нарт сэтгэлийн дэм хайрлаж, 3 хүмүүжигчийг олон жил уулзаагүй гэр бүлтэй нь уулзуулах ажлыг зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд аймгийн Эрэгтэйчүүдийн холбооноос “Эр хүний үнэ цэнэ”, “Аз жаргалын хөг аялгуу”, “Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол” зэрэг сэдвээр хүмүүжигч нарт сургалт, нөлөөллийн ярилцлага зохион байгуулсан.

“Эв нэгдлээр манлайлья” уриан дор Төвийн бүсийн залуучуудын чуулган 07.30-31-ны өдрүүдэд Дүнжингарав бөхийн дэвжээнд зохион байгуулагдаж, Төв, Сэлэнгэ, Дархан, Орхон аймгууд, Улаанбаатар хотын Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн залуучуудын холбооний төлөөлүүд нийт 400 гаруй залуучууд оролцон, орон нутаг дахь залуучуудын хөгжил-оролцоо, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол зэрэг нийгмийн болоод залуучуудад тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх арга замын талаар санал солилцлоо.

Залуучуудын хөгжлийн төвөөс санаачлан хэрэгжүүлж байгаа “Нэг хөгжлийн зөвлөл-Нэг сайн дурын ажил” аяныг зарлан аяны хүрээнд ЗХТ-ийн дэргэдэх "Сайхан бүхнийг сайн дураараа" клубын гишүүд Зуунмод хотын цэцэрлэгт хүрээлэнгийн орчны хог хаягдлыг цэвэрлэх, авто машины зогсоолын өнгө будгийг тодруулан будах ажуудлыг зохион байгуулсан.

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлөөс 08.08-09.27-ны хооронд 27 суманд аймгийн Засаг даргын баталсан удирамж, төлөвлөгөө, маршрутын дагуу “Хамтдаа урагшиль” аялах, туг дэвтрийг 4 бүст хуваан амжилттай аялуулж, туг дэвтрийг хүлээн авсан сум бүр үр дүнтэй ажлыг зохион байгуулж байна.

Залуучуудын хөгжлийн төв аймгийн Цагдаагийн газартай хамтран гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний дүрэм зөрчиж хариуцлага хүлээж, түр саатуулагдсан 9 хүмүүжигчид "Гэр бүлийн харилцаа" сэдвээр зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулав.

Залуучуудын хөгжлийг дэмжих Оролцоод Манлайлъя сарын аяны хүрээнд Мэргэжлийн чиг баримжааг тодорхойлох цахим сорилийг цахим сүлжээнд байршуулан олон нийтийн түгээн ажиллалаа. Хандалтын тоо: 26414, мөн Төв аймгийн залуус ТББ-тай хамтран Уран зургаар дамжуулан хүүхэд багачуудад урлагийн боловсрол олгох, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх, бүтээлээр уран зургийн үзэсгэлэн гаргаж, сургалт зохион байгуулсан. Сургалтанд 28 хүүхэд хамрагдлаа.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга замыг хэлэлцэн салбар чуулганаас гарсан саналыг Залуучуудын хөгжлийн үндэсний чуулганд хүргүүлэхээр аймгийн удирдлагууд 6 хүний бүрэлдэхүүнтэй цахим чуулганыг зохион байгуулан, 13 сумын 34 залуучуудын төлөөлөл оролцууллаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Монгол Улсын анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төгсөгчдийн багш шавийн уулзалт 2022,08,30-ны өдөр Монгол туургатан театрт зохион байгуулагдлаа.

Уулзалтад аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Засаг даргын орлогч Ц.Буманбуян, АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг, АШУҮИС-ийн төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга Б. Дамдиндорж, МУ-н төрийн соёрхолт, хүний гавьяат эмч, ЭМЯ-ны мэс заслын ерөнхий мэргэжилтэн, АШУҮИС-ийн мэс заслын тэнхимийн зөвлөх, АШУ-ны доктор, профессор О.Сэргэлэн болон АШУҮИС-ийн эрдэмтэн багш нар, ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТ-ийн удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нийт 100 гаруй хүн оролцлоо.

Эрүүл мэндийн салбарын ажилтны өдрийг тохиолдуулан 18 эмч, эмнэлгийн ажилтныг “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” цол тэмдэг, ЭМЯ-ны “Хүндэт жуух бичиг”-ээр тодорхойлон, шагнуулсан. Баянчандмань сумын Эрүүл мэндийн төвийн даргын ажлыг хүлээлцүүлэн, үүрэг чиглэл өгсөн.

Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилт, үр дүнгийн талаар уулзалт, ярилцлага зохион байгуулсан. 26 сум, өрх, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газрын 2023 оны төсвийн төлөвлөгөөний төсөл, 28 эрүүл мэндийн байгууллагын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлсэн.

Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дахь заалт Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 5 эмнэлгийн ажилтанд 21.0 сая төгрөгний тэтгэмж олгосон.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн Зуунмод сумын харъяат эхийн эндэгдлийг хэлэлцэх “Эхийн эндэгдлийн тохиолдлыг магадлан хэлэлцэх зөвлөл”-ийн хуралд ЭМГ, АНЭ, ӨЭМТ-ийн нийт 29 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцон, хэлэлцэж, зөвлөмж шийдвэр гаргахад санал солилцлоо.

Монголын эх барих, эмэгтэйчүүд, нярай судлалын холбоо, Эрүүл мэндийн газар хамтран “Эх, барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх нь” сэдэвт сургалт 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдөр Эрүүл мэндийн газрын сургалтын зааланд зохион байгуулж, 65 эмч эмч, эмнэлгийн мэргэжилтэнд онол, дадлага хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. ЭХЭМҮТ-өөс Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний чиглэлээр зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтад 60 эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан.

Аймгийн хэмжээнд 08 дугаар сард Коронавируст халдвар (Covid-19)-ын 722 тохиолдол бүртгэгдэн, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрууллаа. Үүнээс Зуунмод сумын 245 батлагдсан тохиолдолд тандалт судалгаа хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 46 ор дэлгэн ажиллаж байна. Баруун-Зуунмод ӨЭМТ Хуучин

театрын байранд Коронавируст халдвар /Ковид-19/-ын үед тусламж, үйлчилгээ үзүүлэх, оношлох түр цэгийг байгуулан ажиллаж байна.

Баяндэлгэр суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан, ундны усны 9 сорьцонд шинжилгээ хийж, танита аппаратаар -52 хүн, дотрын эмчийн үзлэгт-28 иргэнийг хамруулсан. Үзлэгт хамрагдсан иргэдэд эрүүл зөв хооллох, дасгал хөдөлгөөн хийх, жингээ хэрхэн бууруулах талаар зөвлөгөө өгч ажиллалаа.

Ковидын үеийн мэдээлэл сургалт сурталчилгаа сайжруулах төслийг ДЭМБ-д хүргүүлж, 15.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 2022 оны 08-11 дүгээр сард хэрэгжүүлэхээр болсон.

ХӨСҮТ-ийн 15.0 сая төгрөгний санхүүжилтээр Эрүүл мэндийн газрын вакцин биобэлдмэл хадгалах өрөө тасалгааны засварын ажлыг хийж байна. 5-11 насны хүүхдийг дархлаажуулах ажлын хүрээнд ХӨСҮТ-өөс 4130 хүн тун вакцин татан авч 26 сумын Эрүүл мэндийн төвд хүргүүлэн, дархлаажуулалт хийгдэж байна.

Коронавируст халдварын голомтын халдваргүйтгэлийг 532 мкв талбайд хийж гүйцэтгэсэн. Сармагчны цэцэг өвчний үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, урьдчилан сэргийлэх зөвлөмжийг сумын Эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн Орчны эрүүл мэндийн лаборатори: Химийн шинжилгээний 6 дээжинд 96 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийж гүйцэтгэсэн. Стандартын шаардлага хангаагүй сорьц илрээгүй.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

ЭМДЕГ-тай гэрээт аймгийн 77 Эрүүл мэндийн байгууллагуудаас эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн 23635 иргэний 2,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн нэхэмжлэлт хяналт хийж, 911 иргэний 189 сая төгрөгний зөрчил илрүүлж, 22724 иргэний 2,2 тэр бум төгрөгний гүйцэтгэлийг ЭМБ-уудад олгохоор ЭМДЕГ-т хүргүүлж, илэрсэн алдаа зөрчийг хасагдсан шалтгаанаар нь нарийвчлан гаргаж ЭМБ-дад хүргүүлсэн.

Баяндэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн өдөрлөгт оролцож ЭМДаатгал болон байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан, сумын ЭМ-ийн эмч, ажилтнуудад ажлын байрны сургалт зохион байгууллаа.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 1 өргөдөл, гомдол, 2 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч ажилласан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтын газраас хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж “Нийгмийн даатгалын тухай хууль”-д заасан болзлоор малчин, хэвийн бус нөхцлөөр тэтгэвэр тогтоолгохдоо хуурамч материал бүрдүүлсэн байж болзошгүй 14 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийг шалгуулахаар Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн. Шалгах ажиллагаанд хяналт тавиулахаар Прокурорын газарт хүсэлт гаргасан.

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-д зааснаар иргэний нэхэмжлэлтэй шүүх хуралд хяналт шалгалт, дотоод аудитын тасгаас 5 удаа нийгмийн даатгалын хэлтсийг төлөөлж гуравдагч этгээдийн үүргээр татагдан оролцсон.

Жирэмсэн амаржсаны тэтгэмж 666 даатгуулагчид 1,126.1 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 1046 даатгуулагчид 139.8 сая, ажилгүйдлийн тэтгэмж 290 даатгуулагчид 660.5 сая төгрөг тус тус олгосон байна. Хаан банк болон Төрийн банкаар дамжуулан 17347 тэтгэвэр авагчдад 8,3 тэрбум төгрөгийн тэтгэврийг аймгийн хэмжээнд олгон ажилласан.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ:2022 оны 8-р сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэр 1900 иргэнд 4087,6 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1227 иргэнд 812,6 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламж 1056 иргэнд 615,7 сая төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 25 иргэнд 30 сая төгрөг, алдарт эхийн одонтой 9702 иргэнд 1249,3 сая төгрөг, 1430 ахмад настанд 254,4 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, насны хишиг 5760 ахмадад 916,6 сая төгрөг, 278 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 59 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, жирэмсэн 1447 эхэд 185 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4954 иргэнд 1567,2 сая төгрөгийн тэтгэмж, өрх толгойлсон 319 иргэнд 254,5 төгрөг, ихэр хүүхэд

төрүүлсэн 19 иргэнд 38 сая төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 125 ирэнд 5 сая төгрөг тус тус олгосон.

Нийгмийн хөгжлийн чиглэлээр: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн хамт олны бүлгийн төсөл хэрэгжүүлж, ажлын байр бий болж, өрхийн орлого нэмэгдүүлэх төслийн сонгон шалгаруулалтад 7 сумын 4 бүлгийн төслийг хүлээн авч ажлын хэсгийн хурлаар оруулан хэлэлцүүлж, дэмжлэг авсан төслийн бүлгийн ахлагч, гишүүдтэй гэрээ байгуулах ажил хийгдэж байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн мөнгөний талаар: 0-18 хүртэлх насны 60 хүүхдийг и-халамж системээр бүртгэж 33950 хүүхдэд 27066,5 сая төгрөгийг олгосон. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 730 өрхийн 5438 иргэнд 410,9 сая төгрөгийн 10 нэр төрлийн бүтээгдэхүүн олгож хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлж ажилласан.

Зуунмод сумын 40 өрхийн 50 хүүхдэд Холт олон улсын байгууллагаас хүүхэд тус бүрт сард 15\$-ийн тусламж үзүүлж байна. Мөн “Хүүхдийн амьжиргааг дэмжих” төсөл хөтөлбөрийн зохицуулагч Зуунмод суманд ажиллаж, хөтөлбөрт хамрагддаг хүүхдүүдтэй уулзаж, нөхцөл байдлын үнэлгээ хийн, ивээн тэтгэгч нарт хүргүүлэх талархалын захидал, зурагт мэндчилгээ бүхий явцын тайлан хүргүүлэн ажилласан.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 8-р сарын байдлаар 25 ажил олгогч, 57 иргэнийг ажил хайгчаар бүртгэлээ. Шинээр бий болсон 54 /нийт 604/-н шинэ ажлын байрыг бүртгэн мэдээллийн санд оруулсан. Нийт 21 ажил олгогчийн 77 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 15 /нийт 405/ иргэн ажилд зуучлагдлаа. Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдах 76 иргэнд, бүртгэлд хамрагдсан тодорхойлолт гаргаж нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн. Түр ажлын байранд ажилласан 154 /нийт 5367/ иргэнийг бүртгэж мэдээллийн санг үүсгэн ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт Лел металл, Илт Гоулд, Уулс Заамар зэрэг ХХК-аас 16 иргэний 76984,2 мянган төгрөг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрсөн байна. Мөн 1051400,0 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн бөгөөд тайлант сард 669531.1 мянган төгрөгийг зарцуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд: “Эрхэм таныг урьж байна” цахим уулзалтыг 1 удаа зохион байгуулж, орон нутгийн ТВ, цахим хаяг, аймгийн төвийн багуудад мэдээллийг хүргэж ажиллалаа. Ярилцлагын үр дүнд 7 ажил олгогчийн 58 захиалгыг хүлээн авч, 7 иргэнийг ажлын байранд зуучилсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд: Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэ, Баянжаргалан, Өндөрширээт, Дэлгэрхаан, Угтаалцайдам, Цээл зэрэг 11 сумын малчдыг малжуулах арга хэмжээнд хамруулж мах, сүү, ноолуурын чиглэлийн 723 толгой малыг хүлээлгэн өгч иргэдийн өрхийн амьжиргаанд 55,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг ХЭДСангаас зарцууллаа. Малжуулах арга хэмжээнд 2021-2022 онд хамрагдсан өрхүүдийн /гэрээний хугацаа хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа/ гишүүдээс 18 өрхийн эмэгтэйчүүд сүү цагаан идээ боловсруулах сургалтад хамрагдах хүсэлт өгсөний дагуу Эрдэнэ сумын МСҮТөвтэй гэрээ байгуулан 3 төрлийн чадамж эзэмшүүлэхээр 5 хоногийн сургалтыг хамтран зохион байгууллаа. Сургалтаар эмэгтэйчүүд шар сүүгээр чихэр, цэлцэгнүүр, ундаа, чанамал зэрэг 7 төрлийн бүтээгдэхүүн, ислэг таргаар сүүн хурууд хийх технологийг сурч 3 төрлийн ааруул, эззгийг хийж сурсан байна.

ХЭДСангийн санхүүжилтээр бизнесийн үйл ажиллагаа явуулж буй иргэдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулахаар Зуунмод сумын “Төв Керамик” компанийн борлуулалтын цэгийг түрээслэн ажиллаж байгаа бөгөөд энэ сард шинээр 7 иргэний 4 төрлийн бараа бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгч, нийт 22 иргэний бүтээгдэхүүнийг борлуулж байна. Тус компанид 7,8-р сарын түрээсийн төлбөр болох нийт 1,2 сая төгрөгийн санхүүжилтийг ХЭДСангаас олгосон бөгөөд энэ сард өссөн дүнгээр 14,1 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулж, иргэдэд дэмжлэг үзүүлсэн байна.

Ахмадын ХЭДХөтөлбөрийн зөвлөх үйлчилгээнд ажиллаж буй Зуунмод сумын 9 ахмад /Дэлхийн зөн байгууллагад 5 ахмад, Аймгийн ЗДТГазарт 4 ахмад/, Баянчандмань суманд 1 ахмад, Борнуур сумын 2 ахмад, Дэлгэрхаан сумын 1 ахмадтай онлайнаар уулзаж, ажлын явц, хүндрэл бэрхшээлтэй асуудлын талаар ярилцлаа. Дээрх 13 иргэнд олгох 14,0 сая төгрөгийн санхүүжилт 2022 оны 11-12 сард олгохоор хүлээгдэж байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн цахим сургалтад Заамар, Батсүмбэр, Архуст, Баянчандмань, Зуунмод сумын 18 эмэгтэй хамрагдан, нягтлан бодох бүртгэл суурьтай мэргэжлийн ур чадварын сургалт, хувь хүний хөгжлийг дэмжсэн хөдөлмөрт бэлтгэх сургалт, цахим орчинд бизнесийн талбараа нээж, хөтлөх ур чадварыг эзэмшихээр Сонор сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан сургалтад амжилттай суралцаж, мэргэжлийн чадамжийн 2-р зэргийн гэрчилгээ болон сургалтын сертификатаа хүлээн авлаа. Сургалтад бага насны 2-6 хүүхэдтэй, ажилд зуучлагдах боломжгүй, хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хөдөлмөр эрхлээгүй ээж нар оролцсон бөгөөд сургалтын зардалд нийт 3,9 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.

Оролцоо төслийн Эхний шатанд 18 иргэн оролцсоноос 10 иргэн ажил олгогч байгууллагууд дээр дадлага хийж, 6 иргэний дадлага бүрэн дуусгаад байна. 3-р ээлжийн сургалтад 2 иргэн нэмж хамрагдсан.

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Төв түмний цэнгэл наадмыг 07.29-нд Баянцагаан суманд зохион байгуулан үндэсний сур 50, үндэсний бөхийн барилдаанд 32, шагайн харваанд 25 багийн 200 гаруй харваачид, нийт 282 тамирчин хамруулсан. Ахмадын хөдөлгөөн эрүүл мэнд өдөрлөгийг Аргалант суманд 08.03-нд зохион байгуулж урлаг, спортын төрлүүдээр 9 сумын 168 ахмад хамрагдлаа.

Өлзийт нуурын тойром харваанд 16 багийн 128 харваач оролцож 1-р байр С.Эрдэнэбаатар ахлагчтай УБ, 2-р байр Т.Энхбат ахлагчтай Төв аймаг, 3-р байр П.Пүрэвцэрэн ахлагчтай Аргалант сум тус тус шалгарлаа.

Самбо жү-догийн Азий аварга, Хүүхдийн дэлхийн аварга, Увс аймагт зохион байгуулагдсан “Үндэсний Цом-2022” болон 21 аймгийн аварга шалгаруулах хөл бөмбөгийн тэмцээнд дэд байр эзэлсэн Төв аймгийн хөл бөмбөгийн залуучуудын шигшээ багийн тамирчдыг Төв аймгийн Засаг дарга хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн.

Дети-Ази-2022 ОУ-ын хүүхдийн 7-р наадмаас Пауэрлифтингийн 80 кг төрөлд С.Заяа хүрэл, Самбо бөхийн 49 кг төрөлд Б.Чинхүслэн хүрэл, Олимпийн 19-р наадам жүдо бөхийн 59 кг төрөлд Д.Номин хүрэл, Өсвөр, залуучуудын Ази тивийн АШТ жүдо бөхийн 70 кг төрөлд Б.Арвин хүрэл медаль хүртсэн амжилтуудыг үзүүллээ.

Монголын бүх ард түмний XV-р наадмын пауэрлифтингийн төрөлд багаараа 4-р байр, Байт харваа багаараа 4-р байр, Дугуйн олон өдрийн уралдаанд багаараа 3-р байр, А.Хүслэн, Т.Амарсанаа нар Спортын дэд мастерийн болзол биелүүлээд байна.

Монголын үндэсний спортын VII их наадмын шигшээ тэмцээнээс Төв аймгийн баг тамирчид 4 алт, 5 мөнгө, 5 хүрэл, нийт 14 медаль хүртэж уламжлалт сурын харвааны төрөлд 2 спортын дэд мастер шинээр төрөн гарч багийн нийлбэр дүнгээр 5-р байр эзэллээ.

НАЙМ. ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:

Батлан хамгаалахын сайдын Төв аймгийн Засаг даргатай 2022 онд байгууласан хамтран ажиллах гэрээний 1.11 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2020 оны 05 сарын А/121 дугаар /Цэргийн бэлтгэл сургалтын хөтөлбөр батлах тухай/ тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны 07 сарын А/420 дугаар захирамжийг тус тус үндэслэн 2022 оны Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Үндэсний Батлан хамгаалахын Их сургуультай хамтран Төв аймагт Зүүн бүсийн аймгуудын /Төв, Дорнод, Хэнтий, Сүхбаатар/ аймаг сумдын Засаг даргын Тамгын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг 2022 оны 08 дугаар сарын 04-өөс 3 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн байрлалд Төв аймгийн Засаг даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу 4 аймгийн 63 сумдын ЗДТГ дарга нартай сургалтыг зохион явууллаа.

Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/50 дугаар тушаал, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 1.9 дэх заалтын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулах Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнд 2022 оны 08 дугаар сарын 20-ноос 27-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн сургалтын нэгдсэн төвийн байрлуулан 21 аймаг, 9 дүүргийн 400 гаруй сурагчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөж Төв аймгийн “Залгамж” тасгийн бэлтгэлийг хангаж амжилттай оролцуулсан.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР